

БАЯНЛИГИЙН ЦАГААН ГОЛЫН ТАРИАЛАН

Алдар Ю.Болдбаатар

С.Юндэнбат

ШУТИС-ийн Хүмүүнлэгийн Ухааны Сургууль, докторант, Bold@mtu.edu.mn

Тулхүүр уг:

Сангай-Эрдэнэ бандид хутагтийн дотоод сан. Энэ сан нь дотроо бадрах сан, Аривжих сан (ул хөдлөх ба эргэлтийн хөрөнгийн) гэж хуваагддаг байжээ

Уурхай-Дараа жил тариалах урийг булж хадгалдаг уурхайлсан нух

Түүрэм-тарийн цайруулахаар засссан утрам

Дэү-Хүндийн хэмжүүр, их, бага янз бүрийн хэмжээтэй 30-40 шанага тарианы багтаамжтай модон дөрвөлж, таар, хялгасаар нэхсэн шуудайгаар хэмжинэ

Тором зэмнэх-Тормыг ачлага эдэлгээнд сургах нэгэн зүйл компанийт ажлыг энэ нутагт ингэж нэрлэнэ

Монгол нутагт шинэ чулуун зэвсгийн болоод хүрэл, төмөр зэвсгийн үед газар тариалангийн суурь тавигдаж улмаар МЭӨ I зууны үед оршин тогтнож байсан Хүнну гүрний үеэс монгол овог аймгууд газар тариалангийн ажлыг мал аж ахуйн хавсрата болгон эрхэлж байсныг археологийн судалгааны олдворууд нотолсоор байна. Баянлигийн хадны зургууд хэмээн алдаршсан Лиг голын баруун нуруу Говийн алтайн салбар Их баян уулын Бичигтийн амны сүг зургийн чуулбар дурсгалын дотроос “хэрэглэх аж ахуйгаас үйлдвэрлэх аж ахуйд шилжсэн хүрлийн хөгжингүй үеийн дурсгал” (1.35) болох үхэрт анжис хөллөн газар хагалж байгаа зураг монголд анх удаа олдсон нь газар зүйн ойр дөт байршилыг харгалзан үзвэл Лигийн голын тариалангийн үүсэл гаралтай ч холбоотой хэрэглэгдэхүүн байж болох үндэстэй юм.

Нутгийн хүмүүсийн дунд Лигийн голын тариалан “Цагаан бар гүний” үед үүссэн хэмээх нэгэн домог одоо хир яригдаг бөгөөд 1923 онд тус шавийн нутгаар аялсан оросын жуулчин П. К. Козлов аяны тэмдэглэлдээ (2), А.Д.Симуков 1927 онд говь нутагт явуулсан шинжилгээний ажлын дүнгийн тухай тайландаа Цагаан бар гүний тухай басхүү дурьдсан байдаг. Тэр цагт Лигийн голын ус нь одоогийнхөөс элбэг байсан учир нэр агч Цагаан Бар гүн тариалангийн үлэмж их талбайд тария тарьдаг байсан тухай уг домогт дурьддаг байна. Бас энэ нутагт Бар гүний гэдэг нэртэй өвөлжөө эдүгээ ч байдаг (3.5) болой. Энэхүү Цагаан Бар гүн хэмээгч нь Гэрсэнэж жалайр хун тайжийн дэд хөвгүүн Ноёндай Хатанбаатарын хоёр дахь үеийн ач бөгөөд уул нутагт XYI-XVII зууны заагт амьдарч Бэсүдийн нэгэн отогийг захирч явсан түүхэн бодит хүн юм. Түүхэн үнэнийг тодорхой хэмжээгээр агуулж буй эдгээр баримт, сурвалж нь Лигийн голын тариалан нь манай түүх бичигт удаа дараа тэмдэглэсэнчлэн манжийн цэргийн тариалангаас үүсэлтэй бус харин түүнээс ч түрүү үеийн уламжлалтай бөгөөд магадгүй монгол нутаг дахь тариалангийн эдэлбэр газрын эртний нэгэн ор буурь энд байжээ гэж үзэх боломжийг бидэнд олгож байна.

XVIII зууны эхээр манж нар халхыг эзлэн аваад ойрдын эсрэг байлдахдаа Лигийн голын тариаланг цэргийн тариалан болгон хэсэг зуур ашигласан ажээ. Энэ тухай манж Чин улсын баруун хойт газрыг түвшитгэн тогтоох бодлогын бичигт:

“Энх Амгалан хааны 56 дугаар оны (1717) тавдугаар сарын цагаан барс өдөр, цагийг бадруулагч жанжин гүн Нуурдийн айлтгасан нь: Энэ жил тарьж боловсруулсан тариалангийн газар тария тарьснаас гадна Аригууцуйц, Шивэр охь, Лиг, Цагаан голын зэрэг газар өн сайн тулд одоо суваг ухаж ус оруулаад цөм нэмж тарьваа. Таван сард бороо орох тулд тарьсан чинжүү, нохойн хошуу, арвай (хуягт арвай), буудай цөм маш сайн ургасан” (4) хэмээн дурьдсан байна.

Дашрамд тэмдэглэхэд, Эрдэнэ бандид хутагт Ламын гэгээний шавийн нутагт урьд нэгэн цагт тариа тарьж байсны ор мөр, шан шуудуу, бул, тээрмийн чулууны үлдэгдэл, Лигийн голоос гадна Түйн хотын балгас, Хар ус, Бултын булан, Улаан дов, Далан түрүү зэрэг газар байдаг болно.

Манж нар ойрдыг эрхэндээ оруулсны дараа дарангуй цэргээ гэдрэг татахад Лигийн гол дахь “алба цэргийн тариалан” орхигдож, тухайн үед шавь захирах эрхийг шинэ тутам аваад байсан халхын анхны тамгатай хутагтын нэг Ламын гэгээний эзэмшилд шилжин гэгээний сан ба жас, дацангудын харьяа тариалан болон хувирсан ажээ. Ийнхүү XYIII зууны дунд үеэс Эрдэнэ бандид хутагтын сан, Лиг, Цагаан голд арвай тариалж хурал номынхоо хэрэгцээнд зарцуулах болсон нь эрхлэх аж ахуйн талаар зэргэлдээ бусад хутагтын шавиас ялгарах нэгэн онцлог нь болжээ.

Лигийн голын тариалан нь газар тариалангийн уламжлалт бус нутгаас алс зайдуу Алтайн өвөр говь дахь харьцангуй бага хэмжээтэй эдэлбэр газарт зуу, зуун жил бие даан оршиж ирэхдээ, тариалах өвөрмөц арга барил, зан үйл, нэр томъёог уламжлан хадгалж үлдсэнээрээ онцлогтой юм. Эдгээрийг судалгааны чухал хэрэглэгдэхүүний хувьд нарийвчлан авч үзэх, газар, тариалангийн бусад бус нутагт хэрэглэж байсан арга технологи, зан үйл, нэр томъёотой харьцуулан судлахад хэрэг болох болов уу хэмээн уг сэдвийг нилээд дэлгэрэнгүй бичихийг зорилоо. Үүнийг бичихэд бага залуудаа ах нараа даган тариалангийн энэхүү эдэлбэр газарт ажиллаж, үлэмж туршлагатай ахмад тариачдын арга туршлагыг ярхай ажиглаж, сүүлд 1954 оноос “Улаан-Оч” нэгдлийн орлогч дарга, сум нэгдлийн даргаар ажиллаж Лигийн голын тариаланг хуучин уламжлалт аргаар нь сэргээн тариалах ажлыг санаачилж байсан Баянлиг сумын харьят эдүгээ өндөр настан Санги овогтой Банди гуайгаас 1994 онд сонсч тэмдэглэсэн хэрэглэгдэхүүнд түшиглэв.

Гэгээн сангийн (сангайн) тариалан нь тусгай дарга даамалтай, 8 дацан тус бүр өөр, өөрийн харьяны айл өрхөөс хүмүүсийг дайчлан ажиллуулж, санд нийлүүлэх тарианы хэмжээг хүн нэг бүрээр тогтоож өгдөг журамтай байжээ. Ажиллагсдын бүрэлдэхүүнийг авч үзвэл “урхай сахисан улсууд” /Уурхай гэдэг нь дараа жилд тариалах үрийг булж хадгалдаг уурхайлсан нүхийг хэлдэг/ гэж гэр оронтойгоо тариалангийн дэргэд ирж суурьшин сууж тогтмол ажилладаг цөөн айлуудын зэрэгцээ “аяганы хийц, хоол хүнсэйгээ” ирж, ажил хийдэг малчид тэдний ихэнх хувийг эзэлж байв. (5.55-56) Тэдгээр малчид хавар эрт ирж газраа засаж, усалж, суваг шуудуу татаж, үрээ суулгаад зун нь ээлжлэн манаж, усалж байгаад намар ургацаа хураан авч дуусмагц 9 сарын сүүлчээр буцдаг байсан ажээ. Ардын аман билэгт “Төөргийн голд төлөг тавьсан юмсан. Түүний нүд нь бултийгээ болов уу, чих нь дэлдиигээ болов уу” гэсэн оньсого байдаг нь чухамдаа мал ба тариалангийн ажлыг энэ мэт хослон эрхэлж ирсэн малчдын сэтгэл зүйгээс урган гарсан буй заа.

Жил бүрийн 3 дугаар сарын хорьдоор “Сангайн тарианд хөдлөх” (гэгээн сангийн тариа) гэж нутгийнхний Ярианд хэвшсэн компанит ажил эхэлдэг байжээ. 1930 онд В. Д. Якимовын тэмдэглэснээр Лигийн голын тариаланд тохиромжтой талбай нь 2,5 мянян га, үүнээс голын зах дагуу 1,5 мянян га, атаржсан хуучин талбайг оруулан тооцоход 2-3 мянян десятин газар болохыг тооцсон ба голын дунд урсгалд нэгэн цагт ашиглаж байсан усан тээрмийн үлдэцийг олж ажигласнаа тус тус бичсэн байна. (6.39-48)

Лигийн тариалан нь элсэрхэг, шавранцар, хуурай хөрстэй. Талбайд нэг жил тариалж, 2-3 жил өнжүүлэн газраа амраах замаар ээлжлэн тариалах систем хэрэглэж байжээ. Тарьдаг тариа нь их төлөв арвай, багахан хэсэг нь улаан буудай байв.(10) Гуравдугаар сарын сүүлчээр газраа засч бэлдэнэ. Хааш хаашаа 6-8м орчим (1 аараас арай бага) талбайг 20 см орчим өндөр, дээгүүр нь хүн явах хэмжээний өргөнтэй хамруудаар дөрвөлжлөн хашиж, голын дагуух өндөр дээрс,

дөвонгуудын дундах чөлөөг дагуулан олон арван нүд гаргаж (ийм нүдийг зээл гэнэ) тариалах талбайгаа засдаг. Эдгээр өндөр довонгууд нь хөрс хамгаалах ойн зурvasын үүрэг гүйцэтгэж, тариаг нарны цохилтоос хамгаалж, салхи шуурганаас нөмөрлөдөг, хөрсний чийгийг барьж тогтоодог чухал үүрэгтэй байжээ. Цагаан голоос авсан гол суваг, түүнээс салбарласан хавирган сувгуудтай. Хавирган сувгаас чих гаргаж талбайг услана. Чих гаргана гэдэг нь хавирган сувгаас сэтэлж зээлрүү ус оруулахыг хэлнэ. Анхны услалтыг газар ус гэнэ. Газар (цэнэг) усалгааг хийхдээ зээлийн хамрыг бараг дүүргээд (хөрс зузаан бол дундуур) чихийг хааж, дараагийн зээлд чих гаргаж усаар дүүргэх зэргээр ээлж дараатай гүйцэтгэнэ. Эндэхийн хөрс шаварлаг тул шингэхдээ удаан байдаг ба ус нь бүрэн шингээд хөрс нь эвэрч, бутарсан нойтон бор шороо болох үед нь үрээ суулгана. Тариалах үрийг зориулалтын ширэн уутанд хийж урдаа зүүгээд гараар атган авч, дунджаар алга дарам газарт 10 ширхэг үр унасан байхаар тохируулж жигд алхамаар цацна. Дараа нь тэмээнд хөллөсөн анжсаар (модон бойтогтой, төмөр хушуутай) газраа хагалж, цацсан үрээ суулгана (булна). Ийнхүү суулгахдаа анжисны хошуугаар ярагдсан шороон зурvas дараагийн зурвастай зах нийлж хамар үүсгэж байхаар бодож анжисны даралт, хагалах гүнийг тохируулна. 25 хоногийн дараа хоёр дахь усалгааг хийнэ. Ер нь нийтдээ 6 удаа (гантай жилд 15 хүртэл) усладаг. “Зургаан устай, зуун хорин настай” гэж арвайгаа хэлдэг нь 120 хоногт 6 услаад боловсордог хэмээсэн үг ажээ. Эхний усалгааг “газар ус”, дараагийнхийг нь “гээзэг ус”, зуны халууныхыг “их ус”, зуны хуучдаар бол “дунд ус” гэх мэт тус бүрдээ нэртэй. Намар есдүгээр сар гаргаад арвайн түрүү шарлаж, өлөн чийгтэй байх үед, тариан түрүүг унахаас нь урьтан тахир (гар) хадуураар хадаж, ишийг нэг тийш, толгойг нөгөө тийш харуулан тавьсаар нэг том тэвэр болмогц голын дэрсээр багцлан боогоод (ийм боодлыг нэг бүүз гэнэ) бүүз, бүүзээр нь түүрмийн (үтэрм) захад эгнүүлэн хурааж, 5-6 хоног хатаана. Тариаг цайруулахад хэсэг бүр тусдаа бэлдсэн түүрэмтэй байх ба түүнийг түрүүлж сулласан нэг том зээлийг тэгшилж засаад хийдэг ажээ. Үүний тул уг талбайд ус оруулаад хөрс нь сайн хатаагүй байхад тэмээгээр өдрийн ихэнхэд гишгүүлэн байж шалддаг. Ингэж шалдсанаар түүрмийн талбай өчүүхэн ч өөгүй няйт хатуу гадаргуутай дугуй шал болдог байжээ. Хэт чийгтэйд нь шалдвал өнгө нь хатахдаа хагарч, завсраар нь тариа орох зайд гардаг тул болдоггүй. Тариан толгойг хатахад бүүзээ задалж, тариагаа түүрмийн энгээр жигд тараан зулаад мориор гишгүүлж цайруулна. Цайруулах тариаг дэлгэж тараахдаа түүрмийн голд нэг хүн зогсох хэмжээний дугуй зайд (хүйс) үлдээнэ. Гишгүүлэх морьдыг (томуохон түүрэмд 12-15, багашигт нь 8-10) ногтоор нь шанаа шанаанд нь бэхлэж, (хазаартай бол зуузайгаар нь) нэгэн эгнээ болгон зэрэгцүүлж холбоно. Нэг хүн, дотор талын морины цулбуураас барьж түүрмийн хүйснээ зогсох бөгөөд холбоотой морьдын араас морьтой хүн тууж, түүрмийн талбайг тойруулан элдэнэ. Морьдыг туучг хүн, дотор талын морьд сажлах, захын морьд нь шогшиж явахаар морьдын явдлыг тохируулна. Тариа гишгүүлэх явцад захын морьд амархан сульддаг тул номхон адууг дотор талд, эмнэг хангалыг нь гадна талд нь оруулдаг байна. Тариаг сүрлээс нь салгаж цайруулах энэ ажил тарианы хатсан эсэхээс шалтгаалан ойролцоогоор хагас өдрийн турш үргэлжилнэ. Ингэж цайруулахад гарсан бүдүүн хивэгийг маахуур гэх ба бас нарийн хөг хивэг тариандаа үлдэнэ. Иймээс цайруулсан тариагаа оройн сэргүүнд хошгоор (модон хүрз) байр сэлгүүлэн цацаж хивгийг нь хийсгэн дахин цэвэрлэнэ. Энэ ажилд “хошуу ялгах” (цайрсан тариа, хийссэн хивэг хоёрыг ялгаж зааглах) хүн нэн хариуцлагатай, туршлагатай хүн байх шаардлагатай байдаг ажээ.

Тарианы ажлын төгсгөлд баяр хийж, дацан бүр өөр өөрийн овоог тахидаг бөгөөд гэгээн сангийн овоо Цагаан цахир толгой дээр байдаг. Бусад 8 дацангийн тахилгын овоо голын захын ааргууд дээр ойр ойрхон байсан ажээ.

“Тэргэл саран мэт дүгрэг

Толь шил мэт гэлгэр

Тал мэт уудам түүрэмдээ

Таван тарианы үрээ
Тамсаг элбэг хураан
Тайван сайхан цайруулаад
Түүнээс хойшдын билгийг бодож
Тавтай билгээтэй түүнийгээ
Даяар олноороо нийлж
Тараг, айргийн дээжээр мялаамуу...”
(Түүрмийн ерөөлөөс)(7.142)

Ийнхүү нэгэн жилийн ажил дуусахад, хэдийг нь санд тушаах, хэдийг ажилласан хүмүүст хувиарлах, хэдий хэрийг гүйсан тоссон хүмүүст гэвсэн (гэвсэн гэдэг нь тарианы хишиг авахаар хормой тоссон хүнд хоёр нэг хүрэз будаа өгч, хувь тараахыг хэлнэ) болгон түгээх тооцоогоо хийнэ.

Хойтон жилийн үрийг хүрэлцэх хэмжээгээр нөөцлөж, талбайн ойр тусгай бэлдсэн нүхэнд дор нь сүрэл дэвсэж мөн дээрээс нь хучиж, шавардаж таглана. Ингээд сан, дацан бүрээс нэг айлыг сахиулаар үлдээнэ. Үүнийг уурхай харах гэнэ.

Тариачид ургацаа хурааж дуусаад намар бүр гэгээн сангийн тэмээн сүрэгчдээс цугласан олон тормонд тариагаа ачиж, Их Богд уулсын өвөр говь дахь Лигийн голоос Хангайн уулсын өвөр бэлд орших Баянзүрхийн хүрээнд /Ламын гэгээний хүрээ/ хүргэж, талдаа 200 гаруй км хол замыг туулж байсан нь тус шавийн хувьд бага насны тэмээг эдэлгээнд сургах шалгарсан арга болж уламжлан хэвшсэн зүйл байжээ. Тором цуглаж, хесөг хөдлөх үеийг нутгийн ярианд “тариан тором хөдлөх”, “Тором зэмнэх” гэж нэрлэдэг бөгөөд нэг тормонд хоёр дэү (Дэү нь их бага янз бүрийн хэмжээтэй. Том дэү нь 40 шанага тарианы багтаамжтай) тариа ачиж ургац барагтай жил 300 гаруй, ургац сайтай жилд 400 орчим тормоор хесөг хөдөлгөдөг байсан ажээ. Ачаа эдэлгээнд анх орж, ижил сүргээсээ холдож буй хэдэн зуун эмнэг торомыг нэгэн дор ачаалж хөдөлгөх гэдэг говь нутагтаяа жилд нэг тохиолдох хөлтэй, дуулиантай ажил байсан төдийгүй тэдгээр тором, буйлтнуудын туйлах, буйлах нь нийлээд үзсэн, оролцсон хүмүүст мартагдашгүй сэтгэгдэл төрүүлдэг нэгэн зүйл сонин содон үзвэр болдог байжээ. Хүрээ хийд орж майдар, дором үзээгүй говийн нэгэн эр “Майдар эргэх гэдэг чинь тариан тором хөдлөхөөс хаашханаа юм болдог вэ” гэж асуусан тухай нутгийн хууччуул одоо хир инээд наадам болгон ярилцдаг билээ.


Сангийн тариаг хэдэн айл өрх эрхлэж, хичнээн хэмжээний талбайд тариалж, хэдий хэрийн ургац авч байсан тухай мэдээ баримт нэн ховор.

1882 онд 9 өрх 59 дүү тарианы алба нийлүүлсний дотроос Балдир гэгч хүн 10 дүү 180 кг тариа тушааж байжээ. /8 / 1886 оны Эрдэнэ бандид хутагтын их санд 19 айлаас 105 дэү 45 жин, гэгээн санд 56 дэү тариа тус тус нийлүүлж байсныг тэмдэглэжээ. (8.36-68)

Гэгээн сан, дацангуйд тариаландаа өөрийн харьяатаас дайчлан ажиллуулж, намар ажлын хөлсөнд 30 шанага шар будаа, 1-2 годил /35-45 кг орчим багтаамжтай жижиг шуудай/ тариа өгдөг (5.55-56), улирал тутамд хонь 1, ямаа 1-ийг олгодог, харин жасууд нь (1920-иод оны дунд үед) 1 аар газрыг 1 шар цай, 2-3 хониор хөлслөн гэрээгээр ажиллуулж байжээ. (9. 39-48)

Лигийн голд гэгээн сан, дацан, жасын зэрэгцээ зарим айл өрх бие даан тариалан эрхэлж байсан мэдээ байдаг бөгөөд 1920 оны байдлаар 25 өрх бага хэмжээний талбайг эзэмшин хувиараа тариалж байжээ. Лигийн голын тариалангийн нийт ургац (сан, дацан, жас, хувь хүмүүс) ойролцоогоор 1000 дэү буюу 1500 орчим пүүд хүрч байсан тухай В. Д. Якимов нутгийн тариачдын яриаг үндэслэн тогтоосон нь буй. Лигийн голын тариалангийн газрыг ламын гэгээний хийдийн гэгээн сан, 8 дацан, жас 1920-иод оны сүүлч хүртэл хуучин янзаар эзэмшин ашиглаж байсан бөгөөд хамгийн сүүлд 1927 онд 700 орчим пүү үр тариаг эндээс хураан авчээ. (5.55-56)

Лиг цагаан голд Ламын гэгээний хөх арвай гэж хол ойрдоо зартай, үнэр, амт сайтай, өсгөлүүн том үр бүхий хуяггүй хөх арвайг эртнээс тариалсаар ирсэн



Баянлигийн хадны зураг

бөгөөд 1920-иод оны сүүлчээс сан, дацангийн тариалан зогссоноор нутгийн энэ шилмэл сортын арвайн үр тасарсан ажээ. Хожим 1939 оны хавар “Улаан чих” хэмээх Аюурын удирдсан “Улаан-оч” нэгдэл тариалах анхны үрээ Өвөрхангай аймгийн Баруун Баян-Улаан сумын нутаг Таацын Улаан дов хавийн айлуудаас олж залгуулсан юм гэдэг.

Ном зүй

- Сэр-Оджав Н. *Баянлигийн хадны зураг*. УБ, 1986
Козлов.П.К. *Путешествие в Монголию. 1923-1926*. Москва, 1949
Маамхүү.Ш. *Их Богд уулын зарим дурсгал*. УБ, 1988
Буянчуулган.Н. *Монголын тариалангийн түүх*. II бүлэг. Улсын төв архив.
Симуков А. *Современная Монголия* УБ, 1936, №1-6
Якимов.В.Д. *Возможности земледелия в Южной гоби /Хозяйство Монголии/* 1930, №5-8
Ж.Саруулбаян. *Ламын гэгээнii цадиг оршивой*. УБ, 1999
УТТА. *Бадаргуулт төрийн 16 онд гэгээн санд тарцаа барьсан хүмүүсийн данс*. ХН. 38
Якимов В. Д. *Хозяйство Монголии*. УБ, 1930 №5-8
Түдэв Б. Батаа С. *Алтангадас одонт Улаан-Оч нэгдэл*. Баянхонгор, 1963

Summary

*Yu. Boldbaatar
S. Yundenbat*

Crop farming of Bayanlig Tsagaan gol

Bayanlig Tsagaan Gol field was cultivated traditionally the crops from ancient Mongols. Middle of the 18th century this place was cultivated by Manchurian soldiers for a short period, and then later it handled to the Lamiin Gegeenii Monastery.

Bayanlig Tsagaan Gol field was located in the Inner Gobi of the Altai Mountain. The field occupied in a small area for long time and it had a peculiarity, which kept its method, custom and term of cultivating.

It's important to compare this field's method, custom and terms of cultivating with another fields.